



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 5/13

Баян-Овоо

Шагналт цалин олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2009 оны 193 дугаар тогтоолын хавсралтын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын тэргүүний сумын шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийн тайланг гаргах, сонгон шалгаруулалтын бэлтгэл ажил хангах, шалгуулах, ном, сэтгүүл, боршур бэлтгэж хэвлүүлэх, илтгэл тавих зэрэг ажилд идэвхтэй ажилласан Засаг даргын Тамгын газрын удирдах албан тушаалтнуудад 1 дүгээр хавсралтаар, суманд ажиллаж байгаа босоо удирдлагатай албан хаагчдад 2 дугаар хавсралтаар мөнгөн шагнал тус тус олгосугай.

2. Засаг даргын тамгын газрын удирдах албан тушаалтнуудын шагналт цалинг байгууллагын цалин сангаас, суманд ажиллаж байгаа босоо удирдлагатай албан хаагчдын шагналын 7037000 төгрөгийг Засаг даргын нөөц сангаас зохих журмын дагуу олгохыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД



010000275